



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндсэн хуулийн цэцийн даргын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: САГ-2026/21/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Бодлого, төлөвлөлт, инновацын газрын дарга: Х.Баярмаа Утас:261729 Цахим хаяг:bayarmaakh@audit.gov.mn Арга, зүй стандарт хариуцсан менежер: Л.Мөнхцацрал Утас:261729 Цахим хаяг:munkhtsatsrall@audit.gov.mn Ахлах шинжээч: Б.Мөнхцэцэг Утас:261729 Цахим хаяг: munkhtsetsegba@audit.gov.mn Шинжээч: Н.Цэрэнбалжир Утас:261729 Цахим хаяг: Tserenbaljirts@audit.gov.mn Шинжээч: С.Цэнд-Аюуш Утас:261729 Цахим хаяг: Tsend-Ayushs@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.27 № 1157
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Үндсэн хуулийн цэцийн даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу аудит хийгдэх байгууллагаас хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын нарийвчилсан горим сорилын үр дүнд илэрсэн худалдан авах үйл ажиллагааны зохион байгуулалт, дуудлагаар ашиглаж буй суудлын автомашины ашиглалт, бараа материалын дансны бүртгэл, тайлагнал, мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээний анхан шатны баримтын бүрдэл, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, байгууллагын дотоод хяналтын тогтолцоо зэрэгтэй холбоотой аудитын тайланд дурдагдсан нийт 114.1 сая төгрөгийн зөрчил нь санхүүгийн тайлангийн материаллаг байдлаас давсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 24 дүгээр зүйлийн 24.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 15 дугаар зүйлийн 15.1.2, 15.2.6, Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журмын 19 дүгээр зүйлийн 19.1 дэх заалтад тус тус нийцээгүй, УСНББОУС 1-ийн 27, 31-р заалт, УСНББОУС 12-ын 35-р заалт, УСНББОУС 17-ын 14-т заасан дотоод

хяналт, бүртгэлийн шаардлагыг хангаагүй, санхүүгийн тайлангийн эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт, зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь тайлант онд Европын зөвлөлийн Венецийн комисстой хамтарсан “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хууль тогтоомжийн шинэтгэл” сэдэвт семинарыг 2025 онд Улаанбаатар хотноо амжилттай зохион байгуулсан нь оны онцлох арга хэмжээ болжээ. Уг хамтарсан семинарт Европын зөвлөлийн Венецийн комиссын төлөөлөгчид болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, гишүүд, Монгол Улсын Их Хурлын гишүүд, Монгол Улсын дээд шүүхийн шүүгч, Европын холбооноос Монгол Улсад суугаа Элчин сайд, Үндсэн хуулийн эрх зүйн эрдэмтэн, судлаач, хуульч, иргэний нийгмийн байгууллагын төлөөлөгч нарын 74 оролцогч хамрагдсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн Аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, Аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхийн хүрээнд өмнөх оноос шилжиж ирсэн болон тайлант онд ирсэн нийт 287 өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдол, тогтоолыг шалгаж, маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж 236-г шийдвэрлэсэн байна.

Тайлант онд Их суудлын 2 хуралдаан, Дунд суудлын 15 хуралдаан, 3 зөвлөлдөөн, Бага суудлын 33 хуралдааныг тус тус зохион байгуулсан нь өмнөх онтой харьцуулахад нийт хүлээн авсан өргөдөл, мэдээлэл, хүсэлт, гомдол, тогтоолын тоо 19.2 хувиар, Цэцийн хуралдаан (Бага, Дунд, Их)-ы тоо 42.4 хувиар өссөн байна.

Хүлээн авсан өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн 70.8 хувь нь Монгол Улсын хууль, 8.4 хувь нь Үндсэн хуулийн Жаран зургаадугаар дугаар зүйлд зааснаас бусад харьяаллын бус, 0.7 хувь нь Ерөнхий сайд, 3.1 хувь нь Монгол Улсын Их Хурлын тогтоол, 8.4 хувь нь Монгол Улсын Их Хурлын гишүүн, 4.2 хувь нь Монгол Улсын Засгийн газрын тогтоол, 4.4 хувь нь бусад асуудалтай холбоотой байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим, сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	124,143.1	216,209.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	529.7	20.8
33	АВЛАГА	3,035.6	25,744.6
35	БАРАА МАТЕРИАЛ	120,577.8	190,443.9
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,945,155.1	4,608,037.9
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,945,155.1	4,608,037.9
392	Биет хөрөнгө	4,396,550.3	4,167,712.7
393	Биет бус хөрөнгө	548,604.9	440,325.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	5,069,298.2	4,824,247.1
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	-	59.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	5,069,298.2	4,824,187.6
51	Засгийн газрын хувь оролцоо	5,069,298.2	4,824,187.6
512	Хуримтлагдсан үр дүн	1,431,338.0	1,186,227.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,557,289.1	1,557,289.1
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	5,069,298.2	4,824,247.1

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,557,245.4	5,398,717.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	47,002.8	393,650.8
120	Нийтлэг татварын бус орлого	47,002.8	38,750.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,510,242.6	5,005,066.7
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,194,547.4	5,643,828.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,194,547.4	5,643,828.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,816,231.5	5,583,770.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,827,615.6	3,596,902.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	350,490.4	444,657.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,674.2	83,624.1
2104	Хангамж, бараа материалын зардал	394,414.1	368,389.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	101,749.5	89,769.3
2107	Томилолт, зочны зардал	60,945.2	77,593.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	176,528.1	106,637.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	838,814.5	816,197.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	378,315.9	60,057.4
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,717.0	3,371.3

2132	Бусад урсгал шилжүүлэг	374,558.5	46,286.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40.4	10,400.1
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(637,302.0)	(245,110.6)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	192,271.2	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(192,271.2)	-
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(829,573.2)	(245,110.6)

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,080,671.2	1,557,289.1	2,260,911.2	5,898,871.4
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,080,671.2	1,557,289.1	2,260,911.2	5,898,871.4
D01	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,080,671.2	1,557,289.1	1,431,338.0	5,069,298.2
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,080,671.2	1,557,289.1	1,431,338.0	5,069,298.2
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(245,110.6)	(245,110.6)
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,080,671.2	1,557,289.1	1,186,227.4	4,824,187.6

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	4,510,242.6	5,043,816.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	38,750.1
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,510,242.6	5,005,066.7
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,510,242.6	5,005,066.7
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	4,426,112.1	5,028,134.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,426,112.1	5,028,134.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,047,796.2	4,945,368.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,868,167.3	3,578,473.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	303,170.9	463,027.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	65,674.2	83,624.1
2104	Хангамж, бараа материалын зардал	400,482.3	364,327.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,614.9	85,081.1
2107	Томилолт, зочны зардал	60,055.2	77,593.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	181,825.1	196,038.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	89,806.3	97,203.8
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	378,315.9	82,766.5
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,717.0	3,371.3

2132	Бусад урсгал шилжүүлэг	374,558.5	46,286.0
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	40.4	33,109.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	84,130.5	15,682.0
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	89,730.5	16,191.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	89,730.5	16,191.0
2200	Дотоод эх үүсвэрээр	89,730.5	16,191.0
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(89,730.5)	(16,191.0)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	(5,600.0)	(509.0)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,129.7	529.7
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	529.7	20.8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	5,054,604,400.0	4,994,666,554.6	(59,937,845.42)	98.8
122005	Төсвөөс санхүүжих	5,054,604,400.0	4,994,666,554.6	(59,937,845.42)	98.8
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,054,604,400.0	4,994,666,554.6	(59,937,845.42)	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,054,604,400.0	4,994,666,554.6	(59,937,845.42)	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,021,497,100.0	4,961,559,254.6	(59,937,845.42)	98.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	3,578,473,300.0	3,578,473,242.6	(57.42)	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	480,913,300.0	463,027,173.0	(17,886,127.00)	96.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	83,652,300.0	83,624,140.0	(28,160.00)	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	371,030,800.0	364,327,285.0	(6,703,515.00)	98.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	92,683,600.0	90,411,100.0	(2,272,500.00)	97.5
2107	Томиллолт, зочны зардал	77,593,200.0	77,593,200.0	-	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	235,358,800.0	206,038,300.0	(29,320,500.00)	87.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	101,791,800.0	98,064,814.0	(3,726,986.00)	96.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	33,107,300.0	33,107,300.0	-	100.0

2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	3,371,300.0	3,371,300.0	-	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	29,736,000.0	29,736,000.0	-	100.0
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	116.0	112.0	(4.00)	96.6
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	56.0	56.0	-	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	56.0	56.0	-	100.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	56.0	56.0	-	100.0
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	9.0	9.0	-	100.0
650003	Ажлын албаны албан хаагч (АА)	25.0	26.0	1.00	104.0
650005	ШУ-ны салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮШУ)	4.0	4.0	-	100.0
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	17.0	17.0	-	100.0
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.0	-	(1.00)	-

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 160.8 сая төгрөгийн алдаа илэрч, дараагийн аудитаар анхаарах асуудалд орууллаа.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/ мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Бараа материалын дансанд 1 жилээс дээш хугацаанд ашиглагдаж буй үндсэн хөрөнгийн шинж чанартай 120 нэр төрлийн 100.5 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн байна.	15	100,504.2	-	-	15	100,504.2	-	-	15	100,504.2	-	-
Лицензийн хугацаа дуусаагүй 2.5 сая төгрөгийн Adobe all apps, 4.9 сая төгрөгийн Creative Cloud for teams All apps 2 программ, 5.8 сая төгрөгийн 29 ш бараа материал, нийт 31 ш 13.2 сая төгрөгийн бараа материалыг зарлагдсан байна.	2	13,173.0	-	-	2	13,173.0	-	-	2	13,173.0	-	-
Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой 1.4 сая төгрөгийн 7 алдааг бараа материалын дэлгэрэнгүй бүртгэлийн эцсийн үлдэгдлийг залруулах.	7		-	-	7	-	-	-	7	-	-	-
Санхүүгийн байдлын тайлан дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэл /анхны өртөг/ 8,393.3 сая төгрөг, жилийн эцсийн тооллогоорх үлдэгдэл 8,404.4 сая төгрөг буюу 11.6 сая төгрөгийн зөрүүтэй байна.	1	11,160.0	-	-	1	11,160.0	-	-	1	11,160.0	-	-
Үндсэн хөрөнгийн дансанд анхны өртгөө нөхсөн боловч ашиглалтад байгаа 489 төрлийн хөрөнгийн дахин үнэлж, бүртгээгүй байна. Санхүүгийн программын алдаанаас 2992 төрлийн үндсэн хөрөнгийн тоо 0 буюу, хасах	1	-	1	-	-	-	-	-	1	-	-	-

утгатайгаар үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайланд тусгагдсан байна.												
Жилийн эцэст хоорондын тооцоогоор үүссэн нийгмийн даатгалын байгууллагад төлөх 2.6 сая төгрөгийн өглөгийг санхүүгийн тайланд тусгаагүй, ажиллагсадтай холбоотой үүссэн 3.0 сая төгрөгийн авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	1	5,633.5	1	5,633.5	-	-	-	-	1	5,633.5	-	-
Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 77.6 сая төгрөгийн гадаад томилолтын зардал зарцуулснаар тайлагнасныг анхан шатны баримттай тулган шалгахад, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх төсвөөс 16.9 сая төгрөгийн гадаад томилолтын зардлыг санхүүжүүлсэн байна. Тайлант онд төсөвт зохицуулалт хийж, зохистой удирдаагүйн улмаас томилолтын зардал гүйцэтгэлээр 94.5 сая төгрөгт хүрч, батлагдсан төсвөөс 16.9 сая төгрөгөөр хэтэрсэн байна.	1	16,956.7	-		1	16,956.7	-	-	1	16,956.7	-	-
Санхүүгийн байдлын тайлан дахь үндсэн хөрөнгийн үлдэгдэл /анхны өртөг/ 8,393.3 сая төгрөг, жилийн эцсийн тооллогоорх үлдэгдэл 8,404.4 сая төгрөг буюу 11.6 сая төгрөгийн зөрүүтэй тайлагнасан байна. Мөн үндсэн хөрөнгийн дансанд 322.8 сая төгрөгийн үнэ бүхий 90 ширхэг суурин болон зөөврийн компьютер бүртгэлтэй боловч тайланд онд Болордуран болон вирусийн эсрэг программын эрхийг тус бүр 100 ширхгийг худалдан авч, бодит хэрэгцээнээс тус бүр 10-г илүү зарцуулж, 2.2 сая төгрөгийн зардал гаргасан байна.	1	13,395.9	1	13,395.9	-	-	-	-	1	13,395.9	-	-
Дүн	29	160,823.3	3	19,029.4	26	141,793.9	-	-	29	160,823.3	-	-

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой нийт 114.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1.2 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 73.9 сая төгрөгийн зөрчилд 6 албан шаардлага, 39.0 сая төгрөгийн зөрчилд 7 зөвлөмжийг тус тус өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Тамгын газар батлагдсан орон тоонд холбогдох чиг үүрэг бүхий хариуцсан албан хаагчид байхад ажил гүйцэтгэх, гүйцэтгүүлэх 4 гэрээ, хөлсөөр ажиллуулах 3 гэрээ тус тус байгуулж, чиг үүргийг давхардуулан ажиллуулж, нийт 30.3 сая төгрөгийн ажлын хөлсийг төсвөөс зарцуулсан байна.	1	30,350.0			1	30,350.0		
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга нь тайлант онд суудлын автомашины үйлчилгээ авах зорилгоор Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-тай "Эрх бүхий албан тушаалтанд суудлын автомашинаар үйлчилгээ үзүүлэх тухай" гэрээ байгуулж, суудлын автомашиныг жилийн турш нийт 6,322 км ашиглаж, үйлчилгээний хөлсөнд 10.4 сая төгрөгийг илүү ашиглалтын төлбөрт зарцуулсан байна. Мөн тус гэрээний үйлчлэлд үл хамаарах албан хаагчийн машин түрээсийн ажил, үйлчилгээний хөлсөнд 4.7 сая төгрөгийг Засгийн газрын авто баазын дансанд шилжүүлсэн байна.	1	15,109.30			1	15,109.30		
Тайлант хугацаанд 9.9 сая төгрөгийн 14 ширхэг бэлэг дурсгалын зүйлийг зардлын эдийн засгийн ангилал зөрчиж, өөр өөр зардлын ангиллаас санхүүжүүлэн худалдан авсан, 4.4 сая төгрөгийн байгууллагын лого бүхий 80 ширхэг зангиа худалдан авсан зэрэг нь төрийн хэмнэлтийн бодлоготой нийцэхгүй байна.	1	14,253.7			1	14,253.7		
Албан хаагчдын албан хэрэгцээнд зориулж Засгийн газрын автобазаас "эрх бүхий албан тушаалтанд суудлын автомашинаар үйлчилгээ үзүүлэх тухай" гэрээ байгуулан, холбогдох зардлыг тээвэр шатахууны	1	9,920.0			1	9,920.0		

зардлын төсвөөс зарцуулсан байна. Автомашины ашиглалтын байдлыг нарийвчлан хянахад бүх нийтийн амралтын өдөр /25/-өөр ашиглаж, 9.9 сая төгрөгийн зардал гаргасан байна.								
Өмнөх оны аудитаар тогтоосон 2 төлбөрийн актыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх байтал байгууллагын төсвийн хөрөнгөөр барагдуулсан байна. Тухайлбал, автомашины зогсоолын түрээсийн төлбөрт төлсөн 1.8 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлээгүй байгууллагын төсвөөс барагдуулсан, мөн гадаад томилолтын зардлыг давхардуулан олгосон 0.9 сая төгрөгийн төлбөрийн актаас 0.6 сая төгрөгийг 6 албан тушаалтны цалингаас суутган барагдуулсан боловч үлдэгдэл 0.3 сая төгрөгийг буруутай албан тушаалтнаар төлүүлэлгүй байгууллагын төсвөөс барагдуулсан байна.	1	2,124.0			1	2,124.0		
Өөрийн хөрөнгөд бүртгэлгүй буюу Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас түрээсээр ашиглаж байгаа автомашинд техникийн хяналтын үзлэг хийлгэхэд 1.0 сая төгрөг, явах эд ангид сэлбэг хэрэгсэл, тосолгооны материал худалдаж авах үйлчилгээний зардалд 1.1 сая төгрөг нийт 2.1 сая төгрөгийг байгууллагын урсгал засварын зардлаас зарцуулсан байна. Уг асуудлаар өмнөх оны аудитаар зөвлөмж өгсөн боловч хэрэгжилт хангагдаагүй бөгөөд ижил төрлийн зөрчил давтан гарсан байна.	1	2,114.6			1	2,114.6		
Тайлант онд 8 удаагийн гадаад албан томилолтоор ажилласан 16 албан хаагчид томилолтоор ажиллах хугацаанд 1.2 сая төгрөгийн хоол, унааны зардлыг давхардуулан тооцож олгосон байна.	1	1,185.0	1	1,185.0				
Бараа материалын үлдэгдэлд хийсэн тооллогоор 2.5 сая төгрөгийн уран зураг, 3.0 сая төгрөгийн цом, нийт 5.5 сая төгрөгийн хөрөнгө дутсан зөрчил илэрсэн бөгөөд эдгээр эд зүйлсийг холбогдох албан тушаалтанд дурсгасан боловч бараа материалын зардлын гүйлгээний баримтыг бүрдүүлж, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй байна. Мөн бараа материалын зарлагын гүйлгээнд эрсдэлд суурилсан нарийвчилсан сорил хэрэгжүүлэхэд анхан шатны	1	14,825.1					1	14,825.1

баримтын бүрдэл дутуу 6.0 сая төгрөгийн гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Бараа, материалын үлдэгдэлд хэрэгцээ шаардлагаас илүү нөөцөлсөн болон эргэлт удааширсан 2.3 сая төгрөгийн 102 ширхэг "Implementation of constitutional review" судалгааны тайлан, 0.9 сая төгрөгийн 250 ширхэг "МУ-ын үндсэн хууль", нийт 3.3 сая төгрөгийн хөрөнгө хадгалагдаж байна.								
Жижиг мөнгөн сангийн дансанд нийт 12.7 сая төгрөгийн орлогын гүйлгээ шилжүүлж, зарцуулсан боловч 3.0 сая төгрөгийн буцалтгүй тусламж, 1.6 сая төгрөгийн дэмжлэг тусламжийн зардлын анхан шатны баримт бүрдэл дутуу, 8.0 сая төгрөгийн зарлагын гүйлгээний зориулалт нь тодорхойгүй байна. Байгууллагын харилцах данс хооронд гүйлгээ хийх, жижиг мөнгөн сангаас бэлэн мөнгө авч зарцуулах, түүнийг баримтжуулах, тайлагнах эрх, үүргийг нягтлан бодогч ганцаар хэрэгжүүлж байгаа нь нягтлан бодох бүртгэлийн хяналт, хариуцлагын тогтолцоог алдагдуулж байна.	1	12,604.0					1	12,604.0
Тайлант онд албан хаагчид илүү цагаар ажилласны нэмэгдэл хөлс олгохдоо хийсэн ажлын тодорхой баримт, илүү цагийн бүртгэл, нотлох баримтгүй нийт 10.0 сая төгрөгийг олгосон байна.	1	10,000.0					1	10,000.0
Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас түрээсэлсэн болон зарим албан хаагчийн хувийн автомашинд нийт 11.0 сая төгрөгийн шатахууны талон олгосон байна. Бараа материалын гүйлгээнд хяналт тавихад шатахууны талоны жилийн эцсийн үлдэгдлийг 1.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.	1	1,590.0					1	1,590.0
Тамгын газрын санхүү, төсвийн удирдлага, үйл ажиллагаанд тавих дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, хөрөнгө, бараа материалыг бэлтгэж, холбогдох журналыг хөтөлж, тайланг бэлтгэх мэргэжлийн нярав байхгүй, төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нягтлан бодох бүртгэлийн ажил гүйлгээг бүртгэх, тайлагнах үйл ажиллагааг нягтлан бодогч дангаар хариуцан хэрэгжүүлж байгаа нь чиг үүргийн	1						1	

давхцал, ажлын ачаалал үүсгэж, хяналт, хариуцлагын механизмыг алдагдуулж байна.								
Тамгын газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/25 дугаар захирамжаар баталсан албан хаагчдын албан тушаалын ангилал, зэрэглэлд Хяналт-шинжилгээ үнэлгээ, дотоод хяналт хариуцсан референтийн орон тоог баталсан боловч, хариуцсан албан хаагчийг томилж ажиллуулаагүй байна. Тайлант онд санхүү төсвийн хүрээнд эрсдэлийн удирдлагаар хангаагүй, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж, зөвлөмж арга зүйгээр хангах талаар арга хэмжээг аваагүй байна.	1						1	
Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь тайлант онд суудлын автомашины үйлчилгээ авах зорилгоор Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-тай “Суудлын автомашинаар үйлчилгээ үзүүлэх тухай” гэрээ байгуулж, гэрээний хүрээнд 15 суудлын автомашиныг жилийн турш нийт 131,753 км ашигласан нь эрх зүйн үндэслэлийг бүрэн хангахгүй байна. Мөн Засгийн газрын авто бааз ТӨААТҮГ-аас 2 суудлын автомашиныг жилийн турш дуудлагаар ашигласан боловч 3.5 сая төгрөгийн шатахууны зардлыг давхар зарцуулсан байна.	1						1	
Нийт дүн	14	114,075.7	1	1,185.0	6	73,871.5	7	39,019.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудалтай холбоотой нийт 135.3 сая төгрөгийн зөрчил илэрснээс 1 албан шаардлага, 2 зөвлөмжийг тус тус өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Албан шаардлага		Зөвлөмж	
			Тоо	Дүн	Тоо	Дүн
Тайлант онд ерөнхий гэрээний аргаар худалдан авах ажиллагаа зохион байгуулж, цахим дэлгүүрээс худалдан авалт хийлгүйгээр нийт 115.3 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг шууд худалдан авалт хийсэн байна. Мөн 2025 оны 02 сарын 04-ны өдрийн ТГ/2025-02/07 дугаартай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны программ хангамжийг шинээр хөгжүүлэх 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг гүйцэтгүүлэхдээ нээлттэй тендер зохион байгуулалгүй, шууд гэрээ байгуулан 20.0 сая төгрөгийн урьдчилгаа олгосон байна. Жилийн эцэст гэрээний гүйцэтгэлийг дүгнээгүй, гэрээнд заасан хугацаанд ажлыг хүлээн аваагүй байна. Өмнөх оны аудитаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулаагүй, батлуулаагүй, цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг мэдээлээгүй, ерөнхий гэрээний аргаар худалдан авах бараа, ажил үйлчилгээг цахим дэлгүүрээс аваагүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага өгсөн боловч биелэлт хангалтгүй байна.	1	135,313.6	1	135,313.6		
Өмнөх аудитаар “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт УСНББОУС-ын заалтууд болон Монгол Улсын хууль, дүрэм, журмын шинэчлэгдсэн заалтыг бүрэн тусган шинэчлэх” зөвлөмж өгөгдсөн боловч биелэлт хангагдаагүй байна.	1				1	
Шилэн дансны цахим системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайланг баталгаажуулан мэдээлээгүй байна. Мөн шилэн дансны цахим системд худалдан авах ажиллагааны тайланг мэдээлэхдээ нийт 9 гэрээ байгуулж, 94.4 сая төгрөгийн худалдан авалтыг “харьцуулалтын арга”-аар гэж тайлагнасан боловч тендер шалгаруулалтын төрлийг буруу тайлагнасан байна.	1				1	
Нийт дүн	3	135,313.6	1	135,313.6	2	